

ТӨСӨЛ

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.7 дахь хэсэг, 268¹.1.1 дэх заалт, 269¹ дүгээр зүйлийн 269¹.1.1 дэх заалт, 270¹ дугаар зүйлийн 270¹.1.4 дэх заалт, 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.1, 271¹.1.2 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны ... дугаар сарын ... өдрийн хуралдааны 06/00 дугаартай шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/282 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Чөлөөт бүсийн горим хэрэгжүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.20 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.20.Худалдах, худалдан авах гэрээ, төлбөрийн баримт болон бусад бичиг баримтыг үндэслэн чөлөөт бүсэд байх хугацаанд барааны өмчлөх эрхийг шилжүүлж болно. Өмчлөх эрхийг шилжүүлсэн барааг өөр горимд байршуулах гаалийн бүрдүүлэлт хийлгэхдээ мэдүүлгийн Илгээгч/Экспортлогч хүснэгтэд бараа өмчлөх эрхийг шилжүүлж байгаа хуулийн этгээд, иргэний нэр, Хүлээн авагч/Импортлогч хүснэгтэд өмчлөх эрх олж авч байгаа хуулийн этгээд, иргэний нэрийг бичнэ.”

2.Энэхүү журмын 3.4 дэх хэсгээс “факс” гэснийг, 5.1.5 дахь заалтыг тус тус хассугай.

3.Энэхүү журамд дор дурдсан найруулга бүхий 4.4.9 дэх заалтыг нэмсүгэй.

4.4.9.Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь Татварын ерөнхий хуулийн 28.2, 28.5 дахь хэсэгт заасныг мөрдөж, борлуулалт хийх тухай бүр цахим төлбөрийн баримтыг бараа худалдан авсан үйлчлүүлэгчдэд олгох.

ДАРГА

Б.АСРАЛТ

